



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ЦУВРАЛ №2

2023 он

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО нь дараах чиг үүрэг бүхий Төрийн байгууллага:

- санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах;
- санхүүгийн үйлчилгээг зохицуулах;
- холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО нь дараах зах зээл, салбарт хяналт, зохицуулалт тавин ажиллаж байна.



ХӨРӨНГИЙН
ЗАХ ЗЭЭЛ



ДААТГАЛЫН
ЗАХ ЗЭЭЛ



БАНК БУС САНХҮҮГИЙН
БАЙГУУЛЛАГУУД



ХАДГАЛАМЖ,
ЗЭЭЛИЙН ХОРШОО



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ



ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ
ЗУУЧЛАЛЫН
БАЙГУУЛЛАГУУД



ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭГЧ



СЭНДБОКС
ЗОХИЦУУЛАЛТЫН
ОРЧИН



МӨНГӨН ЗЭЭЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭГЧ /2023 он/

Үйл ажиллагааны ЗАРЧИМ:



БИЕ ДААСАН



ИЛ ТОД БАЙХ



БУСДЫН НӨЛӨӨНД ҮЛ
АВТАХ



САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ



НИЙТИЙН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ
АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ

БҮРЭН ЭРХ:

Хэрэгжүүлтэд
хяналт тавих:



Санхүүгийн үйлчилгээтэй холбоотой ХУУЛЬ
ТОГТООМЖ;



Санхүүгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох,
түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн
НӨХЦӨЛ, ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЖ БАЙГАА ЭСЭХ;



Бүрэн эрхийнхээ хүрээнд ДҮРЭМ, ЖУРАМ, ЗААВАР
БАТАЛЖ.

Зөвшөөрөл эзэмшигч,
бүртгэлтэй этгээдийн ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ШАЛГАХ;



Санхүүгийн зах зээлийн ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫГ ДЭМЖИХ зорилгоор
шаардлагатай ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
БУСАД ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООХ;



Зөвшөөрөл эзэмшигч хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч
хооронд гарсан МАРГААНЫГ эрх хэмжээнийхээ хүрээнд ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ.



МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Мөнгө угаах гэдэг нь: Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.

Өөрөөр хэлбэл: Гэмт хэрэг үйлдэх замаар олсон “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны болгохыг **мөнгө угаах гэмт хэрэг** гэнэ.



Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй түгээмэл арга:

- 1 Мөнгөн гуйвуулгын үйлчилгээг ашиглах
- 2 Криптовалютаар шилжүүлэх
- 3 Хандив, тусламж өгөх
- 4 Хавала, хунди зэрэг хууль бус сүлжээ ашиглах
- 5 Хууль бусаар улс дамжиж бараа тээвэрлэх
- 6 Залилан, хулгай дээрэм хийх
- 7 Хувийн мэдээлэл хулгайлж мөнгө нэхэх
- 8 Хууль бусаар үнэт металл, үнэт чулуу олборлох
- 9 Хандив, тусламжийн мөнгийг зүй бусаар ашиглах

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргүүд:



МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ҮЕ ШАТ



1. БАЙРШУУЛАХ

Хууль бусаар олсон мөнгөө санхүүгийн систем рүү нэвтрүүлэх



2. НУУН ДАЛДЛАХ

Бохир аргаар олсон мөнгийг нуун далдлах



3. БУЦААН ТӨВЛӨРҮҮЛЭХ

Тансаг хэрэглээ, хөрөнгө оруулалт руу шилжүүлэх

БИД ЯАГААД МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР МЭДЭХ ЁСТОЙ ВЭ?

“Мөнгө угаах гэмт хэрэг”-ийн сөрөг нөлөө нь юу юм бол доо...



- Эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдалд **сөргөөр нөлөөлнө**;
- Санхүүгийн системийн **тогтвортой байдлыг алдагдуулна**;
- **Хямрал** бий болно;
- Олон улсын түвшинд дотоодын банк, санхүүгийн байгууллагын **нэр хүнд унана**;
- Банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан хийгдэж буй **гадаад гүйлгээг саатуулан, шалгана. Харилцахаас татгалзана**;
- **Хээл хахууль, авлига** нэмэгдэнэ;
- **Шударга, чөлөөт өрсөлдөөний зарчим алдагдана**;
- Улсын төсвийн орлого буурч, **шударгаар татвараа төлж буй иргэд хохирно**.



БОНД ГЭЖ ЮУ ВЭ?

Бонд гэдэг нь: Тогтмол орлоготой, эрсдэл багатай үнэт цаас.

Компанийн бондод хөрөнгө оруулж байгаа нь **тухайн компанид мөнгө зээлж байна** гэсэн үг ба үүний хариуд **компани ашигтай ажилласан эсэхээс үл хамааран** хөрөнгө оруулагчид үндсэн мөнгө болон хүүг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлдөг.

БОНДЫН ХУГАЦААНЫ АНГИЛАЛ



Богино хугацаатай
/1–3 жил/



Дунд хугацаатай
/3–5 жил/




Урт хугацаатай
/5–аас дээш жил/

БОНД БОЛОН ХУВЬЦААНЫ ЯЛГААТАЙ ТАЛ

БОНД

1. Тодорхой хугацааны дараа **эргэн төлөгдөнө**
2. Зээлдүүлэгчийн хувьд **зээлийн хүүг авна**
3. Хөрвөх чадвар хувьцаанаас сул
4. Зээлийн хугацаанд хүчинтэй
5. Компани дампуурвал өөрийн зээлдүүлсэн хөрөнгийг хүүгийн хамт **хамгийн түрүүнд авна.**



1. **Эргэн төлөгдөх нөхцөлгүй**
2. Өмчлөгчийн хувьд өөрт ногдох **ногдол ашиг хүртэнэ**
3. Хөрвөх чадвар сайтай
4. Компани оршин тогтнох **бүхий л хугацаанд хүчинтэй**
5. Компани дампуурвал өөрт ногдох хөрөнгийг өр төлбөр, зээлийг барагдуулж **дууссаны дараа авдаг.**

ХУВЬЦАА




Монгол Улсын хамгийн анхны
дигитал бонд гарсан шүү.

Дигитал гэж онцолж байгаа нь бүх шат дамжлага **аппликейшн дээр** хийгдэнэ. Хамгийн анхны дигитал бонд 2021 оны 11 дүгээр сард гарсан.

Тийм үү? Бас **ногоон бонд** гаргах боломжтой болсон юм байна лээ.

Үнэт цаас гаргагч нь **ногоон бонд** зарахдаа борлуулалтын орлогыг байгаль орчинд ээлтэй төслүүдэд зориулах үүрэг хүлээдэг.



НОГООН БОНДООР САНХҮҮЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД



Нөхөн сэргээгдэх
эрчим хүч



Эрчим хүчний үр
ашигтай зарцуулалт



Байгальд ээлтэй
тээвэр



Дахин ашиглах хог
хаягдлын менежмент

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭРЭГСЛҮҮД





НОГООН ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Монгол Улсад ногоон даатгалыг: Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан “Ногоон таксономи”-ийн ангилалд хамаарах үйл ажиллагааг аливаа хэлбэрээр даатгаж буй сайн дурын даатгалын бүтээгдэхүүн гэж тодорхойлсон.



“Ногоон даатгал”-ын гол онцлог нь юу юм бол доо...

Байгаль орчинд ээлтэй ногоон төсөл, хөтөлбөрүүдийг аливаа эрсдэлээс хамгаалах, мөн хөрөнгө оруулалт, урт хугацааны санхүүжилтийг бий болгодог.



Байгаль орчинд ээлтэй, дахин ашиглаж болох материал, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглахыг дэмжих, урамшуулах хөшүүргийг бий болгодог.

НОГООН ДААТГАЛЫН ЭРЭГ НӨЛӨӨЛӨЛ



Хүрээлэн буй орчинд эергээр нөлөөлнө



Нийгмийн хариуцлагыг сайжруулна



Олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлнэ

- 1 Хүртээмжтэй санхүүжилт, эрүүл мэнд
- 2 Уур амьсгал болон байгалийн гамшигт уян хатан дэд бүтэц
- 3 Тогтвортой хөдөө аж ахуй ба ойжуулалт
- 4 Ногоон барилга, хүлэмжийн хийн бага эсвэл тэг ялгаралтай тээврийн хэрэгсэл
- 5 Тогтвортой ус болон хог хаягдлын менежмент

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Санхүүгийн зохицуулах хороо ногоон даатгалын бүтээгдэхүүнийг тодорхойлж, бүртгэдэг боллоо.

Жишээ нь:



Приус

автомашины даатгал



МОНГОЛ УЛСАД



Унадаг дугуйны
иж бүрэн даатгал

НОГООН ДААТГАЛ – ОЛОН УЛСАД

Олон улсад ногоон даатгалыг: байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэж буй эрсдэлийг бууруулах, даатгуулагч эрсдэлд ороход даатгалын нөхөн төлбөр олгох зориулалт бүхий даатгалын үйл ажиллагаа гэж тодорхойлдог.

ОЛОН УЛСАД БОРЛУУЛАГДАЖ БУЙ НОГООН ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Байгаль орчинд ээлтэй даатгал



Байгаль орчинд ээлтэй, дахин боловсруулагдахуйц материал ашиглах, эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгслийг худалдан авах үед хийгддэг.

Автотээврийн хэрэгслийн ногоон даатгал

Автомашинаараа хэдэн километр явснаас хамааран даатгалын хураамж төлдөг. Нийтийн тээврээр зорчих, алхах зэрэгт төлөх хураамжийн хэмжээ буурдаг.



Бизнесийн ногоон даатгал



Бизнес эрхлэгчид эрчим хүчний хэмнэлттэй цахилгаан хэрэгсэл ашиглах, байгальд ээлтэй стандартаар үйл ажиллагаа явуулах зэрэгт хамаардаг.

Аялал жуулчлалын ногоон даатгал

Аялал зугаалгад явахдаа байгаль орчинд ээлтэй тээврийн хэрэгслээр зорчих үед хийгддэг.



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ

“ **Биржийн бус зах зээл** нь үнэт цаас гаргагчийн цаг хугацаа, зардлыг хэмнэж, богино хугацаанд санхүүжилт татах, мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгон гаргасан үнэт цаасны хоёрдогч зах зээл бий болох, хөрвөх чадвар сайжирч, мэдээллийн ил тод байдал хангагдах зэрэг давуу талыг олгодог. ”

Ямар материал
бүрдүүлэх вэ?



Үнэт цаас гаргагч нь үнэт цаас анх удаа болон нэмж гаргах бол **Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны Бүртгэлийн хороонд** дараах бичиг баримтыг хүргүүлнэ.

01 Үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлт

02 Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

03 Андеррайтерийн мэдэгдэл

04 Андеррайтерийн дүгнэлт

05 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр

06 Үнэт цаасний төслийн танилцуулга

07 Аудитын дүгнэлт

08 Бүртгэлийн үйлчилгээний хөлс төлсөн баримт

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА



Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам болон өөрийн эрх зүйн баримт бичгийг бүрэн дагаж мөрдөх

ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангах

Эрх бүхий албан тушаалтнууд нь компанийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай байх

Үнэт цаас гаргагч нь нэгээс доошгүй жил тухайн чиглэлээр тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх

Дотоодод болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын зарчмыг дагаж мөрддөх



ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГЫН ШААРДЛАГА /"Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.1 дэх заалт/



- 1 Үнэт цаас гаргагчийн тухай мэдээлэл
- 2 Шинээр гаргах үнэт цаас болон тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийн талаарх мэдээлэл
- 3 Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцож буй этгээдийн тухай мэдээлэл
- 4 Үнэт цаасны төслийн танилцуулгад холбогдох бичиг баримтыг хавсаргана



Бүртгэлийн хороо нь ирүүлсэн хүсэлт, журмаар тогтоосон баримт бичгийг ажлын 5 өдрийн дотор хянаж үнэт цаасыг бүртгэх эсэхийг шийднэ.

Үнэт цаас гаргагч нь дараах мэдээллийг тогтмол хугацаанд олон нийтэд мэдээлнэ

1

Санхүүгийн тайланг дараах хугацаанд:

- хагас жил тутам жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор;
- жилийн эцсийн тайланг дараа жилийн 3 дугаар сарын 01-ний дотор;
- аудитлагдсан санхүүгийн тайлан бэлэн болмогц жилийн эцсийн тайланг шинэчлэн оруулна.

2

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан болон үнэт цаасны хүү, эргэн төлөлтийн тайланг улирал тутам;

3

Тухайн тайлант жилийн компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги, тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон өөрчлөлтийн талаарх жилийн тайлан мэдээллийг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний дотор.



Бүртгэлийн хороо нь үнэт цаасыг бүртгэхээр шийдвэрлэсэн нөхцөлд үнэт цаасанд үсгэн код, нэр олгон бүртгэх ба **"Бүртгэлийн гэрээ"** байгуулан мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.

Бүртгэлийн хорооны шийдвэрийг Үнэт цаас гаргагч эс зөвшөөрвөл зохих журмын дагуу гомдол гаргах эрхтэй.

ФИНТЕК ГЭЖ ЮУ ВЭ?

“Финтек” нь Financial technology гэсэн холбоо үгийн товчлол бөгөөд уламжлалт санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлт, хэрэглээг сайжруулах, автоматжуулахад чиглэсэн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн юм.

ФИНТЕКИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО

нь Технологийн дэвшил, инновацийн шийдэл болох хиймэл оюун ухаан, блокчэйн, их өгөгдөл, үүлэн технологи дээр тулгуурлан хөгжүүлсэн программ хангамж, аппликэйшн, алгоритм, процесс, бизнесийн загваруудаар дамжуулан уламжлалт санхүүгийн үйлчилгээг хамгийн бага зардлаар, хурдан шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх юм.



Финтекийн хөгжлийн түүх

Судлаачид финтекийг хөгжлийнх нь хувьд 4 үе шатанд хуваан авч үзэж байна.



- 3.5-р үе шат**

Сүүлийн жилүүдэд хөгжиж байгаа орнуудын дундаас финтекийн хэрэглээгээр тэргүүлж буй Хятад, Энэтхэг зэрэг улсуудын хэрэглээний түвшинг харуулсан.
- 3-р үе шат**

2008 оноос өнөөг хүртэл: Криптовалют, мобайл төлбөрийн шийдэл, краудфандин платформ, P2P төлбөрийн системийг нэвтрүүлсэн.
- 2-р үе шат**

1967–2008 он: Анхны ATM, NASDAQ, SWIFT, цахим худалдаа, онлайн банкны үйлчилгээ, гар утасны хэрэглээ, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийг зах зээлд нэвтрүүлсэн.
- 1-р үе шат**

1886–1967 он: Телеграф, морзын код, трансатлантик кабель, федвайр зэрэг тухайн үеийн технологийг ашиглан анхны цахим технологиор мөнгө шилжүүлэх системийг идэвхжүүлсэн.

ФИНТЕК БҮТЭЭГ ДЭХҮҮНҮҮД

Финтекийн үйлчилгээг олон улсын түвшинд нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах чиглэлээр түлхүү хөгжүүлж байна

1	Хиймэл оюун ухаан болон бот		Утасны автомат хариулагч болон робот технологи ашиглан санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ.
2	Краудфандинг		Төсөл болон бизнесийг санхүүжүүлэх зорилгоор онлайн платформоор дамжуулан олон тооны хувь хүнээс хөрөнгө оруулалт татах технологи.
3	Дижитал банк		Банкны уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, зайнаас санал болгодог.
4	Гар утаснаас санхүүгийн үйлчилгээ		Интернэт орчинд хөдөлгөөнт төхөөрөмж (гар утас, таблет)-ийг ашиглан санхүүгийн үйлчилгээ авах технологи.
5	Нууцлалын аюулгүй байдал, биометрик		Царай, хурууны хээ, дуу хоолой болон биеийн бусад хэсгийг таниулж, санхүүгийн гүйлгээ хийх технологи.
6	Блокчэйн болон криптовалют		Байршлаас үл хамааран төвлөрсөн сервер удирдлагын функцгүйгээр өөр хоорондоо шууд холбогдож арилжаа хийх технологи.
7	P2P зээл		Гуравдагч этгээдийн зуучлалгүйгээр бие биетэйгээ шууд харилцаж, зээл авах төвлөрсөн бус платформ.
8	Валют арилжаа		Цахим валютын бирж нь улс хооронд болон дотооддоо валют солилцох интернэтэд суурилсан платформ.
9	Хөрөнгө оруулалт		Хувьцаа, бонд болон бусад төрлийн хөрөнгө оруулалтын цахим арилжаа.
10	Хөнгөлөлт урамшууллын систем		Худалдааны байгууллагууд байнгын үйлчлүүлэгчиддээ зориулж хөнгөлөлт, урамшуулал олгох дижитал технологи.

ФИНТЕК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД:

Давуу тал:



Сул тал:



1

Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 24 цагийн турш үйлчилгээ авах боломжтой, хугацаа, зардал хэмнэдэг, үйлчилгээний шимтгэл бага.

1

Хувь хүний мэдээлэл, гүйлгээний нууцлал алдагдах, кибер халдлагад өртөх эрсдэлтэй, зөвхөн интернет орчинд ажилладаг.

2

Залилан мэхлэлт, луйврын эрсдэлийг бууруулдаг.

2

Зохицуулалтгүйн улмаас хэрэглэгчийг хохироох магадлалтай.

3

Хүссэн үедээ арилжаанд оролцох боломжтой, хөрөнгө оруулагчийн хувьд сонголт ихтэй, ил тод.

3

Гүйлгээг буцаах боломжгүй, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн баталгаа муу.

4

Хэрэглэхэд хялбар, хүртээмжтэй, олон талт, хөрвөх чадвар өндөр.

4

Зарим тохиолдолд ямар дансруу нэвтрэх болон гүйлгээ хийх мөнгөн дүнгийн хязгаарлалт тавьдаг.

5

Үйл ажиллагааг нь хянах, төсөл болон бизнесийг сайжруулах чиглэлээр саналаа илэрхийлж, хамтран оролцох боломжтой.

5

Хүссэн мэдээлэл, үйлчилгээгээ бүрэн авах боломж, хэрэглэгчийн нэмэлт хүсэлтийг шийдвэрлэх байдал хомс, мэргэжилтнээс зөвлөгөө авах боломжгүй.





ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

Барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд.

Жижиг дунд үйлдвэр эрхлэгч та зээл авахыг хүсэж байгаа боловч барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй байна уу?



Танд дараах боломжуудыг санал болгож байна.

№	Зээлийн батлан даалтын төрлүүд	Зээлийн дээд хэмжээ	Зээлийн хугацаа	Батлан даалтын хэмжээ	Батлан даалтын дээд хэмжээ
1	Үндсэн батлан даалт 	Банкны зээлийн нөхцөлөөр	Банкны зээлийн нөхцөлөөр	Зээлийн 60% хүртэл	420.0 сая төгрөг
2	ББСБ-ын батлан даалт 	80.0 сая төгрөг хүртэл	4 жил	Зээлийн 60% хүртэл	48.0 сая төгрөг
3	Азийн хөгжлийн банкны эх үүсвэртэй батлан даалт 	2.0 тэрбум төгрөг хүртэл	10 жил	Зээлийн 30%–60% хүртэл	1.2 тэрбум төгрөг
4	Ажлын байрыг дэмжих 3%-ийн хүүтэй зээлийн батлан даалт 	500.0 сая төгрөг хүртэл	3 жил	Зээлийн 60% хүртэл	300.0 сая төгрөг

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТ ГАРГАХ ДАРААЛАЛ



ЖДҮ эрхлэгч зээл хүссэн материалаа банк, санхүүгийн байгууллагад өгнө.



Банк, санхүүгийн байгууллага нь дүгнэлтээ зээлийн батлан даалтын санд ирүүлнэ.



Зээлдэгч болон банк, санхүүгийн байгууллагатай батлан даалтын гэрээ байгуулна.



Банк, санхүүгийн байгууллага нь батлан даалттай зээлийг олгоно.

БАТЛАН ДААЛТТАЙ ЗЭЭЛ АВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС



Барьцаа хөрөнгөнд хэдэн төгрөгийн зээл, батлан даалт гаргуулах боломжоо үнэлэх



Бизнесийн үйл ажиллагааны үр ашгаас зээлээ эргүүлэн төлөх боломжийг тооцох



Үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлд худалдах боломжтой үнэлгээ банк, санхүүгийн байгууллагын шалгуур, нөхцөлийг хангасан байх



Барьцаанд тавих үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлд худалдах боломжтой нийлбэр дүн нийт барьцааны 40%-аас хэтрэхгүй байх



Зээл авах банк, санхүүгийн байгууллагын зээлийн нөхцөлийг харьцуулан судлах



Зээлдэгч болон түүний холбогдох этгээд нь гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангаагүй тохиолдолд дахин батлан даалт гаргахгүй

БАТЛАН ДААЛТТАЙ ЗЭЭЛИЙН ДАВУУ БОЛОН ДУТАГДАЛТАЙ ТАЛУУД

Давуу тал



1

Барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчид зориулагдсан

2

Зээл авах банк санхүүгийн байгууллагаа чөлөөтэй сонгох боломжтой

3

Зарим төрлийн зээлийн хүү бага



Дутагдалтай тал

1

Зээлийн зориулалтыг хатуу заасан

2


Зээлийн эргэн төлөх хугацааны хувьд уян хатан биш

3

Зээлийн хэмжээ болон батлан даалтын хэмжээ хязгаартай

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО ГЭЖ ЮУ ВЭ?

“Хадгаламж, зээлийн хоршоо гэдэг нь гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг хэлнэ” гэж **Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд тодорхойлсон.**



Ашгийн төлөө бус		Бүтэц, зохион байгуулалт		Ашгийн төлөө
Гишүүдийн хэрэгцээ, шаардлагыг хангах		Анхдагч зорилго		Ашиг олох
Бүх гишүүд		Үйлчлүүлэгч		Шалгуур хангасан хүн бүр
Сайн дураар		Удирдлага		Цалин хөлсөөр ажиллуулдаг захирал
Бүх гишүүд /гишүүн бүр 1 саналын эрхтэй/		Шийдвэр гаргалт		Хувьцаа эзэмшигч 1 хувьцаа=1 санал
Зөвхөн гишүүдэд		Ашиг хуваарилалт		Зөвхөн хувьцаа эзэмшигчдэд
Бага шимтгэл хураамжтай		Хүү, шимтгэл		Ашгийн төлөө ажилладаг тул өндөр
Үйл ажиллагааны орлого		Хөрөнгийн эх үүсвэр		Орлогын урсгал + хувьцаа гаргах
Өмч хөрөнгө, зээлийн үйл ажиллагаанаас олсон ашигт ажиллагаанаас		Татвар		Өмч хөрөнгө, бүхий л орлого олох үйл ажиллагаанаас

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО



Гишүүдийн эзэмшил бүхий санхүүгийн хоршооллын байгууллага

Market Business News. "Credit Union"




Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний давуу тал:

- 01 Газар зүйн байршил, цаг хугацаанаас үл хамааран санхүүгийн үйлчилгээ хүртэх
- 02 Өндөр хадгаламжийн хүүгийн өгөөж хүртэх
- 03 Бага шимтгэл хураамж төлөх
- 04 Гишүүд хоорондын хамтын ажиллагаа нэмэгдэх
- 05 Зээлийн бага шаардлага


ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн хоршоо бол гишүүдээ хамгийн эхэнд тавьдаг зарчимд суурилсан цорын ганц санхүүгийн байгууллага юм.


ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ХӨГЖИЛ




ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 9 ЗАРЧИМ



Гишүүдийн ардчилсан удирдлага, хамтын хяналттай, ил тод, нээлттэй байх




Сайн дурын гишүүнчлэлтэй байх




Ялгаварлан гадуурхахгүй байх



Гишүүдийн эдийн засгийн тэгш оролцоог хангаж, шударга хуваарилалт хийх




Хараат бус, бие даасан байх



Санхүүгийн тогтвортой байдлыг хангах



Бусад ХЗХ-той хамтран ажиллахыг эрэлхийлэх



Нийгмийн болон гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийн төлөө санаа тавих



Гишүүд, ажилтныг сургалт, мэдээллээр хангах

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН ЗУУЧЛАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлал гэдэг нь: үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь агентаараа дамжуулан таны хүсэлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйлчилгээг таны нэрийн өмнөөс мэргэжлийн түвшинд гүйцэтгэхийг хэлнэ.



Тус бүрчлэн тайлбарлаад өгч болох уу?

Тэгэлгүй яхав



Үл хөдлөх эд хөрөнгийн харилцаанд бүх зүйл гэрээний дагуу байна



Үл хөдлөх эд хөрөнгө гэдэгт:




Худалдаа үйлчилгээний талбай



Үйлдвэрлэлийн барилгууд



Амьдран суух зориулалттай байр орон сууц



Газар

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйлчилгээнд үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг:



худалдах, худалдан авах, шилжүүлэх



худалдан авч, засварлан борлуулах



түрээслүүлэх, түрээслэх, хөлслүүлэх, хөлслөх



менежментийн үйлчилгээ

Агент гэдэг нь дээрх үйлчилгээг хэрэгцээт талуудад мэргэжлийн түвшинд үзүүлэх чадвартай албан ёсны эрхтэй зуучлагчийг хэлэх ба талуудыг эрх тэгш төлөөлнө.


АГЕНТААР ҮЙЛЧЛҮҮЛСНИЙ ДАВУУ ТАЛ

- 1 Цаг хугацаа хэмнэх
- 2 Залилан, гэмт хэргээс сэргийлэх
- 3 Найдвартай байдал
- 4 Зөвлөгөө мэдээлэл авах
- 5 Хүсэж байгаа үл хөдлөхөө хурдан хугацаанд олох



Санхүүгийн зохицуулах хорооноос үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагааг зохицуулах журмыг баталсан. Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын компаниудын бүртгэл Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд нээлттэй байршсан тул та тэдгээр байгууллагуудаас сонгон зуучлалын үйлчилгээ авах нь илүү найдвартай байх бөгөөд эрсдэл багатай байх юм.

ХЭРХЭН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ ВЭ?



Та зуучлалын компаниа сонгож агенттайгаа холбогдон өөрийн захиалгаа хэлснээр агент нь таныг мэдээллээр хангах юм. Та тусгай зөвшөөрөлтэй зуучлалын компанийн жагсаалтыг дараах QR кодыг уншуулан хараарай.



Та сонголтоо зөв хийгээрэй.

ҮНЭТ ЭДЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Үнэт эдлэл гэдэг нь: Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн гоёл чимэглэлийн зүйлсийг (бөгж, хүзүүний зүүлт, ээмэг, бугуйвч гэх мэт) хэлнэ.

Эрдэнэсийн сангийн тухай хуульд зааснаар:

"үнэт металл" – алт, мөнгө, платина болон түүний бүлэгт багтдаг палладий, иридий, родий, рутений, осмийг;



"үнэт чулуу" – доржпалам, бадмаараг, маргад эрдэнэ, индранил, сувдыг;



Үнэт эдлэлээ зөв сонгоход **карат /сорьц/** чухал үүрэгтэй байдаг

Жишээ болгон алтыг авч үзвэл **карат гэдэг нь** үнэт эдлэлийг хийхэд хичнээн хэмжээний алт орсныг хэмждэг нэгж юм.



Үнэт металлээр хийсэн эдлэл дээрх карат /к/-ын тэмдэглэгээ нь сорьц

24k– 99.9% сорьцтой буюу цэвэр алт;
18k– 75% алт, 25% бусад металл гэх мэт.



Карат нь 2 утгыг агуулдаг



Үнэт чулуун дээрх карат /сг/- ын тэмдэглэгээ нь түүний жин



1ct– 200мг;
0.5ct– 100мг-тай тэнцэх гэх мэт



ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХДАА АНХААРАХ ЗӨВЛӨМЖ

Үйлдвэрлэгчийн барааны тэмдэг, улсын сорьцын баталгааг шалгах



дээрх тэмдгүүд нь мэдэгдэхгүй, балархай, цифрүүдийн шрифтийн хэмжээ харилцан адилгүй зэрэг эдлэлийг хийсэн металл нь үнэт металл биш байх магадлалтай.



Үнэт эдлэлийг таних хамгийн энгийн арга нь үнэ юм



үнэт чулуун шигтгээтэй алт, мөнгөн эдлэл нь их өндөр үнэтэй байх бөгөөд хямд байвал үнэт эдлэл биш гэж ойлгож болно.



Үнэт эдлэлийн жин, чулуун шигтгээ зэргийг шалгуулах



эдлэлийн нэр, сорьц, жин, чулуун шигтгээний нэр, байгалийн, таримал, дуураймал аль нь болох, карат зэргийг бичүүлсэн гэрчилгээг авах.



Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах журмыг баталсан.



Та дараах QR кодыг уншуулж худалдан авалт хийх гэж буй газар тань тусгай зөвшөөрөлтэй эсэхийг шалгах боломжтой.



Тусгай зөвшөөрөлтэй гэдэг нь **баталгаатай гэсэн үг биш** бөгөөд та хариуцлагаа өөрөө хүлээх тул сайтар нягталж сонголтоо хийгээрэй.



СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН:



- Технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загвар
- Зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор
- хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд турших.

СЭНДБОКСЫН ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
- ✓ Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;
- ✓ Хувьцаа эзэмшигчид, удирдах түвшний албан тушаалтнууд нь өмнө нь мөнгө угаах болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгэлгүй байх;
- ✓ Хувьцаа эзэмшигчийн оруулж буй хувь хөрөнгө нь Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх;





Сэндбоксын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь:



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй;

Сэндбоксын хугацаанд үйл ажиллагаа явуулах, үүсэж болзошгүй эрсдэлийг нөхөх санхүү, төлбөрийн чадамжтай;

Хэрэгжих боломжтой, техник, эдийн засгийн үндэслэл, санхүүгийн үр ашгийн тооцоо хийгдсэн;

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчдийн хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;

Санхүүгийн тогтвортой байдалд заналхийлээгүй;

Хэрэглэгчдэд санал болгоход бэлэн болсон, технологийн хөгжүүлэлт нь шаардлагатай хэмжээнд хийгдсэн;

“Сэндбокс зохицуулалтын орчны журам”-д заасан технологийн шаардлагыг хангасан;

Санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа эсхүл ижил төстэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад үр өгөөж өндөртэй, зардал багатай байх;



ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

ЦУВРАЛ №2

“Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр”-ийн хүрээнд иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулав.



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia

